

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Тавигдах шаардлага
1	Зөвшөөрөлтэй байх	Улсын бүртгэлийн гэрчилгээ хүчин төгөлдөр байх
2	Нэг өдөрт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчийн дундаж тоо	Өдөрт дунджаар 450-500 эмчлүүлэгч
3	Нэг хэвтэн эмчлүүлэгчийн 1 өдрийн хоолны чанар, хоол олгох давтамж	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/440 дүгээр тушаал: Эмчлүүлэгч өдөрт өвчний онцлог, үе шатаас хамаарч 4-6 удаа хооллоно.
4	Ээлжийн эмч, сувилагч, ажилчдын хоолны чанар	Өдөрт дунджаар 120-130 ажилтан хамрагдана. Ээлжийн эмч, сувилагч, ажилчид ЭМС-ын 2017 оны А/74 дүгээр тушаалын дагуу физиологийн нормын хэрэгцээг хангасан /2400 ккал/ байна. Өглөө илчлэгийн 25-30% Өдөр илчлэгийн 35-40% Орой илчлэгийн 25-30% хоол авна /Хөндлөнгийн шалгалтаар илэрсэн аливаа зөрчил, дутагдлыг Гүйцэтгэгч байгууллага хариуцах/
5	Ажилчдын цайны газрын хоолны төрөл, хоолны тариф, чанар	Хоолны төрөл, чанарт онцгой анхаарч ажиллах ажилчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх; Ажилчдын хоолны тусдаа цэстэй байх
6	Бараа материалын нөөц	Гамшиг, цар тахал зэрэг онцгой үед бараа материалын 3 сараас доошгүй нөөцтэй байх
7	Нийт талбай 578 мкв	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолын дагуу түрээсийн гэрээ байгуулж төлбөр төлнө. Ашиглалтын зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцана: Ус, дулаан, цахилгаан, хог хаягдал

8	Гэрээ хэрэгжүүлэх хугацаа болон санхүүжилт	<p>Гэрээ хэрэгжүүлэх хугацаа: 2024.06.20-2027.06.20-ны өдрийг дуустал</p> <p>Дараагийн худалдан авах тендер зохион байгуулагдаж гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулах хүртэл сунгаж болно.</p> <p>Санхүүжилт: Санхүүжилтийг сар бүрийн гүйцэтгэлийн тайланг 2 талаас баталгаажуулж нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30-45 хоногийн дотор төлнө. /Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс шалтгаалсан төлбөрийн хүлээгдэл гарсан тохиолдолд үйл ажиллагааг тасалдуулахгүй 1-2 сарын санхүүгийн чадамжтай байх/</p>
---	--	---

Үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлага:

Эмчилгээний хоол:

1. Эрүүл мэндийн технологи: Зонхилон тохиолдох өвчний үеийн хоол эмчилгээ MNS 5991:2009 болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/440 дүгээр тушаалаар батлагдсан “Хоол эмчилгээний удирдамж”, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан /хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг батлах тухай” тушаалыг үндэслэл болгон эмчилгээний хоолоор үйлчилнэ;
2. Эмчилгээний болон нийтийн хоолны 7 хоногийн үлгэрчилсэн цэсийг сар бүр шинэчлэн боловсруулж, хоол тус бүрийн технологийн картуудыг үйлдэн баталгаажуулсан байх;
3. Өдөрт авах багц хоолны захиалгын тоо ачааллаас шалтгаалан буурч, нэмэгдэж болно. Тухайн өдөрт хэвтүүлэн эмчилж буй өвчтөний тоогоор захиалга хийнэ;
4. Хоолны захиалгын мэдээний дагуу эмчилгээний хоолны технологийн карт, батлагдсан хоолны цэсийн дагуу өдрийн 4-6 удаагийн хоолыг бэлтгэн үйлчилнэ;

Эрүүл ахуй, халдвар хамгаалал:

1. MNS4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавихдах шаардлагыг ханган ажиллах.
2. MNS CAC RCP 39:201 "Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал"
3. MNS 6392:2013 Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага стандартуудыг үндэслэл болгоно.
4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын үйл ажиллагааны технологийн шат дамжлага нь нэг чигийн урсгалтайгаар зохион байгуулна.
5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид жилд 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж эрүүл мэндийн дэвтэр хөтөлсөн байна.
6. Хүнсний түүхий эд, материалыг гарал, үүсэл, эрүүл ахуйн шинжилгээнд тогтмол хамруулсан байх. Эмчилгээний хоолыг жилд 2 удаа итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлнэ.